



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/52

Хажуу шинэ ус

Ёс зүйн зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Алтансаргай /Татварын Улсын байцаагч/

Нарийн бичгийн дарга: Г.Булган /Нийгмийн даатгалын Улсын байцаагч/

Гишүүн: Н.Өлзийтогтох /Тамгын газрын дарга/

2.Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрх үүргийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг ёс зүйн зөвлөлийн дарга /Д.Алтансаргай/-д үүрэг болгосугай.

3.Ёс зүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрийг байгууллагын хэмжээнд дагаж мөрдлөг болгон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нийт ажилчдад даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/36 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН